



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар A/75

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан томилолтоор ажиллуулах журам”-ын 2.1, 3.1, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэлийг Өмнөговь аймаг дахь Мэргэжлийн хяналтын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийг хүлээлцэх ажлаар орон нутагт зорчих удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан томилолтын тайланг ажлын 5 өдөрт багтаан танилцуулахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т даалгасугай.

3. Албан хаагчийн томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА




Б.ЦЭНГЭЛ

132013683

ТӨБЗГ тушаал-/2023

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний  
өдрийн 4/35 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ӨМНӨГОВЬ АЙМАГТ ТОМИЛЛОТООР  
АЖИЛЛАХ УДИРДАМЖ

**Зорилго:** Өмнөговь аймаг дахь Мэргэжлийн хяналтын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийг хүлээлцэх

**Хугацаа:** 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс 10 дугаар сарын 07-ний өдрүүдэд;

**Хаана:** Өмнөговь аймаг;

**Гүйцэтгэх ажлын хуваарь:**

Д/д	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Гүйцэтгэх мэргэжилтэн
1	Мэргэжлийн хяналтын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийг хүлээлцэх	2023.10.04- 2023.10.07	Д.Нарангэрэл

----- о 0 о -----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн  
125 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ  
ЗАРДЛЫН ТӨСӨВ

Өмнөговь аймаг дахь Мэргэжлийн хяналтын барилга, байгууламж, хөдлөх хөрөнгийг хүлээлцэх албан хаагчийн албан томилолтын зардлын төсөв.

**Хугацаа:** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл 10 дугаар сарын 04-ний өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдрүүдэд /хуанлийн 4 хоногоор/ хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/
1	2	3
1	Байр, хоол	472,000
	<b>Нийт дүн:</b>	<b>472,000</b>

**Тайлбар:** Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталсан "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалыг үндэслэв.